



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/4/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442582 Цахим хаяг: [Munkhbatb@audit.gov.mn](mailto:Munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер: А.Цээням  
Утас: 70444470 Цахим хаяг: [teenyana@audit.gov.mn](mailto:teenyana@audit.gov.mn)  
Аудитор: Б.Баасанбат  
Утас: 96442101 Цахим хаяг: [Baasan.bataa@yahoo.com](mailto:Baasan.bataa@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БААЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

2020.02.27 № 1/274

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Д:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

\* 005020228

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2.1. Оршил

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Д.Мөнхцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээхүүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.10-наас 2020.02.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Глобал капитал аудит ХХК-ны аудитор Б.Баасанбат хариуцаж хэрэгжүүлэв.

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.12.18-ны өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баацагаан сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Боловсролын үйлчилгээг ард иргэд хүүхэд багачуудад чанартай хүргэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх хүүхдэд ээлтэй аюулгүй сургууль болох гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна".

Баацагаан сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, хүүхдийн хэрэгцээ сонирхлыг харгалзан адил тэгш оролцоог хангах
- Сургалтын алба, мэргэжлийн зөвлөлөөр хамтран ажлын байран дээр мэргэжил, заах арга зүй, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх
- Хүүхдийн хүмүүжил төлөвшил, хөгжлийн асуудлаар эцэг, эх, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль болох
- Насан туршийн боловсролын үйлчилгээг хамран сургах тойргийн иргэдэд хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамдөөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баацагаан сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баацагаан сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны "Аcolouc" програм хангамж ашигладаг байна.

Баацагаан сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баацагаан сумын Цэцэрлэгийн явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 25 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсонбөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тотоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 180238.7 мянган төгрөгөөс тооцон 3604.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5236.1 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг 3-р улирлаар сонгосонтой холбоотой өөрчлөлт орсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9105,4 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	0	
Урьдчилгаа			
Бараа материал	9183.5	10080.5	897,0
Үндсэн хөрөнгө	716798.2	725006.5	8208.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>725981.7</b>	<b>735087,0</b>	<b>9105.3</b>
Өр төлбөр	283.1	0	-283.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	725698.5	735087.0	9388.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>725981.6</b>	<b>735087.0</b>	<b>9105.4</b>

Тус Цэцэрлэг нь тайлант онд авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 897,0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай материалын худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн 8208,4 мянган төгрөг буюу 0,5 хувиар өссөн нь нь 27246,1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 24310,1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 2936,0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, акталсан 18780,7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна

Өр төлбөр дансны үлдэгдэл 283,1 мянган төгрөгөөр буурсан нь өглөг буурснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 735087.0 мянган төгрөг байгаа ба тайлант оны үр дүнгээр өөрчлөлт орсон болно..

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт байхгүй, алдааны залруулга алдаа байхгүй

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан тусгай зориулалтын шилжүүлгээс 242508,0 мянган, орон нутгийн төсвөөс 24894,5 мянган, нийт 267412,5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 242508,0 мянга, орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилтэд 24894,5 мянган төгрөгийн батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл ТЗШ-ийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг батлагдсан хэмжээнд бүрэн авч, 265463,8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1948,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 265463,8 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого байхгүй байна

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон .25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт горим сорил хэрэгжүүллээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын дүнд алдаа зөрчил илэрээгүй

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны мэдээлэл дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	6	6	6		
2	Хагас жил	2	2	2		
3	Улирал бүр	4	4	4		
4	Сар бүр	12	12	12		
5	Тухай бүр	84	84	84		
	Нийт	108	108	108		

#### 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна

#### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,183,500.28</b>	<b>10,080,500.28</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,183,500.28	10,080,500.28
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,183,500.28	10,080,500.28
35410	Бичиг хэргийн материал	336,200.00	182,800.00
35420	Аж ахуйн материал	8,847,300.28	9,897,700.28
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>716,798,220.92</b>	<b>725,006,542.67</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	716,798,220.92	725,006,542.67
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	709,784,220.92	717,992,542.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	691,154,003.00	691,154,003.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,082,000.00	-16,667,731.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,678,891.00	22,159,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,284,989.91	-11,150,905.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,449,561.00	39,963,516.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,849,774.29	-10,573,760.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,224,230.00	3,224,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,999.88	-1,091,410.00
39217	Ном	1,504,300.00	975,100.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,014,000.00	7,014,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,014,000.00	7,014,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>725,981,721.20</b>	<b>735,087,042.95</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>283,157.96</b>	<b>70.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	283,157.96	70.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	283,157.96	70.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	279,357.96	70.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,800.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>725,698,563.24</b>	<b>735,086,972.95</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	725,698,563.24	735,086,972.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,509,140.00	95,509,140.00
51101	Өмч: - төрийн	95,509,140.00	95,509,140.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-9,766,553.20	-378,143.49
51210	Өмнөх үеийн үр дүн	-9,766,553.20	-9,766,553.20
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,388,409.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	639,955,976.44	639,955,976.44
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>725,981,721.20</b>	<b>735,087,042.95</b>

### 3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>220,432,116.00</b>	<b>275,464,825.80</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>2,936,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	2,936,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,936,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	2,936,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>946,516.00</b>	<b>25,743,625.80</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	219,485,600.00	242,518,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	219,485,600.00	242,518,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	5116,325.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5116,325.80
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	24,894,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,894,500.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	946,516.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	946,516.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>231,980,068.56</b>	<b>265,091,815.92</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>231,980,068.56</b>	<b>265,091,815.92</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	226,406,592.33	258,775,948.87
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	118,555,006.00	156,622,752.08
210101	Үндсэн цалин	116,644,582.00	156,222,752.08
210102	Нэмэгдэл	318,224.00	400,000.00
210104	Урамшуулал	1,592,200.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,269,255.73	19,316,303.00
210201	Тэтгэврийн даатгал	13,593,149.73	13,213,842.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,185,181.00	1,548,294.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,192,032.00	1,261,962.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,489.00	299,292.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,051,404.00	2,992,913.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,469,924.00	21,815,601.00
210301	Гэрэл, цахилгаан	1,344,939.00	1,649,700.00
210302	Түлш, халаалт	29,824,985.00	19,919,901.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	246,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,796,412.00	3,074,923.91

**Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	218,400.00	197,900.00
210402	Тээвэр, шатахуун	889,712.00	939,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,162,700.00	1,177,568.91
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	639,500.00
210408	Бараа материал акталсны зардал	61,600.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,606,400.00</b>	<b>34,103,765.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,500.00	46,715.00
210502	Хоол, хүнс	33,559,900.00	33,965,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	91,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>976,000.00</b>	<b>3,420,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	12,000.00
210602	Тавилга	00.00	270,000.00
210604	Урсгал засвар	976,000.00	3,138,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,000.00</b>	<b>84,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,000.00	84,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>425,000.00</b>	<b>487,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	425,000.00	237,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,224,594.60</b>	<b>19,851,603.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,432,080.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	485,000.00	1,405,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,307,514.60	18,446,603.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,573,476.23</b>	<b>6,315,857.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,663,516.00</b>	<b>4,367,200.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	946,516.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,517,000.00	4,267,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,909,960.23</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,909,960.23	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,948,667.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,948,667.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-11,547,952.56</b>	<b>10,373,009.88</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,440,770.20</b>	<b>984,600.17</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	984,600.17
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	2,440,770.20	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-2,440,770.20</b>	<b>-984,600.17</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-13,988,722.76</b>	<b>9,388,409.71</b>

### 3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>220,432,116.00</b>	<b>272,528,825.80</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>220,432,116.00</b>	<b>272,528,825.80</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	219,485,600.00	242,518,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	219,485,600.00	242,518,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	5,116,325.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,116,325.80
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	24,894,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	24,894,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	946,516.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	946,516.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>220,432,116.00</b>	<b>272,528,825.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>220,432,116.00</b>	<b>272,528,825.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>214,758,639.77</b>	<b>266,212,958.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	123,978,244.00	157,061,543.04
210101	Үндсэн цалин	114,548,400.00	134,769,399.04
210102	Нэмэгдэл	2,984,044.00	12,917,300.00
210104	Урамшуулал	6,445,800.00	9,374,844.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,398,609.77	19,156,800.00
210201	Тэтгэврийн даатгал	10,520,848.77	13,142,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,218,993.00	1,503,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	975,800.00	1,165,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	243,768.00	264,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,439,200.00	3,080,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,537,974.00	21,815,601.00
210301	Гэрэл, цахилгаан	1,412,989.00	1,649,700.00
210302	Түлш, халаалт	29,824,985.00	19,919,901.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	246,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,406,112.00	3,247,723.91
210401	Бичиг хэрэг	153,400.00	91,900.00

**Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	889,712.00	939,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,162,700.00	1,364,068.91
210404	Ном, хэвлэл	50,000.00	51,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,150,300.00	680,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,056,700.00</b>	<b>35,095,165.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,800.00	46,715.00
210502	Хоол, хүнс	33,559,900.00	33,965,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	1,082,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,584,000.00</b>	<b>25,720,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,980,000.00
210602	Тавилга	00.00	17,590,000.00
210604	Урсгал засвар	3,584,000.00	3,150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,000.00</b>	<b>84,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,000.00	84,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>425,000.00</b>	<b>571,912.58</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	425,000.00	321,912.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,288,000.00</b>	<b>3,460,213.22</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	803,000.00	764,213.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	485,000.00	2,696,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,673,476.23</b>	<b>4,315,867.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,763,516.00</b>	<b>4,367,200.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	946,516.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,517,000.00	4,267,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,909,960.23</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,909,960.23	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>1,948,667.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,948,667.05
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

### 3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-4А

#### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийнгазры норуулсанкапитал	Дахинүнэлгээнийнөөц	Хуримтлагдсан дүн	Засгийнгазры нхувьоролцоо нийнийтдүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,509,140.00	639,955,976.44	-9,766,553.20	725,698,563.24
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,509,140.00	639,955,976.44	-9,766,553.20	725,698,563.24
D03	Дахинилэрхийлсэнүлдэгдэл	95,509,140.00	639,955,976.44	-9,766,553.20	725,698,563.24
D09	2019оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,509,140.00	639,955,976.44	-378,143.49	735,086,972.95

### 3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

#### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	219,372,600.00	217,462,639.77	267,412,500.00	265,463,832.95
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	219,372,600.00	217,462,639.77	267,412,500.00	265,463,832.95
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	216,555,200.00	214,645,639.77	267,310,400.00	265,363,832.95
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	125,639,700.00	123,978,244.00	157,853,900.00	157,061,543.04
210101	Үндсэн цалин	114,148,400.00	114,148,400.00	134,769,400.00	134,769,399.04
210102	Нэмэгдэл	5,045,500.00	3,384,041.00	12,917,300.00	12,917,300.00
210104	Урамшуулал	6,445,800.00	6,445,800.00	10,167,200.00	9,374,844.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,501,000.00	15,398,609.77	19,156,800.00	19,156,800.00
210201	Тэтгэврийн даатгал	10,622,500.00	10,520,848.77	13,142,000.00	13,142,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,219,600.00	1,218,993.00	1,503,800.00	1,503,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	975,800.00	975,800.00	1,203,000.00	1,165,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	243,900.00	243,768.00	300,600.00	264,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,439,200.00	2,439,200.00	3,007,400.00	3,080,300.00

**Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,561,100.00	31,512,974.00	21,894,500.00	21,815,601.00
210301	Гэрэл, цахилгаан	1,434,500.00	1,412,989.00	1,649,700.00	1,649,700.00
210302	Түлш, халаалт	29,826,600.00	29,824,985.00	19,944,800.00	19,919,901.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	275,000.00	300,000.00	246,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,343,600.00	4,318,112.00	3,325,500.00	3,247,723.91
210401	Бичиг хэрэг	90,400.00	90,400.00	91,900.00	91,900.00
210402	Тээвэр, шатахуун	890,000.00	889,712.00	940,000.00	939,955.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,162,700.00	1,162,700.00	1,381,700.00	1,364,068.91
210404	Ном, хэвлэл	50,200.00	25,000.00	51,100.00	51,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,150,300.00	2,150,300.00	680,800.00	680,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	34,113,900.00	34,056,700.00	35,928,500.00	35,095,165.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,900.00	46,800.00	47,700.00	46,715.00
210502	Хоол, хүнс	33,616,700.00	33,559,900.00	34,798,000.00	33,965,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,300.00	450,000.00	1,082,800.00	1,082,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,584,000.00	3,584,000.00	25,726,600.00	25,720,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	4,980,000.00	4,980,000.00
210602	Тавилга	00.00	00.00	17,590,000.00	17,590,000.00
210604	Урсгал засвар	3,584,000.00	3,584,000.00	3,156,600.00	3,150,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	93,700.00	84,000.00	95,300.00	84,000.00
210702	Дотоод албан томиллолт	93,700.00	84,000.00	95,300.00	84,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	427,700.00	425,000.00	613,500.00	487,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	427,700.00	425,000.00	363,500.00	237,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1290500.00	1288000.00	2715800.00	2696000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	803,500.00	803,000.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	487,000.00	485,000.00	2,715,800.00	2,696,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2817400.00	2817000.00	102100.00	100000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,817,400.00	2,817,000.00	102,100.00	100,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,517,000.00	2,517,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,400.00	300,000.00	102,100.00	100,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	219,372,600.00	217,462,639.77	267,412,500.00	265,463,832.95
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	219,372,600.00	217,462,639.77	242,518,000.00	240,569,332.95
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	219,372,600.00	00.00	242,518,000.00	240,569,332.95
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	24,894,500.00	24,894,500.00
132001	Орон нутгийн төсвоос	00.00	00.00	24,894,500.00	24,894,500.00

61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16	16	15	15
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	10	10
620003	Үйлчлэх ажилтан	5	5	4	4
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	95	95	95	95
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	95	95	95	95
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	16	16	15	15
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	11	11	10	10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	5	5

### 3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант он
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,116,325.80</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,116,325.80
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,116,325.80</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,116,325.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	849,125.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,267,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,116,325.80
<b>1311</b>	<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,116,325.80</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Б.БААСАНБАТ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТОРЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ